

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСӨЛД ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН АЖИЛЛУУЛАХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар шинжлэх ухаан, технологийн төсөл /цаашид “төсөл” гэх/-д үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн шинжээчийг сонгон ажиллуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“шинжлэх ухаан, технологийн төсөл” гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.4-д заасныг;

2.1.2.“мэргэжлийн шинжээч” гэж судлаачийн мэдээллийн санд бүртгэгдсэн, дараах нийтлэг шаардлагыг хангасан судлаачийг, үүнд:

2.1.2.1.Судалгаа хөгжүүлэлтийн ажил 5-аас доошгүй жил гүйцэтгэсэн;

2.1.2.2.Докторын зэрэгтэй, эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон мэргэшлийн зөвлөх зэрэгтэй байх;

2.1.2.3.Төсөлд удирдагчаар болон гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх;

2.1.2.4.Олон улсад болон дотоодод өөрийн судалгааны ажлын чиглэлээр бүтээл нийтлүүлсэн байх.

2.1.3.“судлаачийн мэдээллийн сан” гэж төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргуулах зорилгоор бүрдүүлсэн судлаачдын талаарх цахим мэдээллийн санг.

Гурав. Судлаачийн мэдээллийн сан бүрдүүлэх

3.1.Судлаачийн мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх ажлыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан зохион байгуулна.

3.2.Судлаачийн мэдээллийн санд мэдүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг судлаач өөрөө хариуцна.

Дөрөв. Шинжээч сонгон ажиллуулах

4.1.Төсөлд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээч нь журмын 2.1.2-т заасан шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд “Судлаачийн мэдээллийн сан”-аас шинжлэх ухааны салбар, чиглэл, мэргэшил, төслийн сэдэв, агуулга, түлхүүр үгийн хамаарлыг үндэслэн сонгоно.

4.2.Төслийн санал бүрд 3-аас доошгүй, сондгой тооны мэргэжлийн шинжээчийг сонгон ажиллуулна. Санхүүгийн хувьд хянан магадлах шаардлагатай гэж үзсэн саналд санхүүгийн шинжээч томилон ажиллуулж болно.

4.3.Мэргэжлийн шинжээч нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах төсөлтэй танилцахаас өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж, баталгаажуулна. Мэргэжлийн шинжээч тухайн төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахаас татгалзсан тохиолдолд дараагийн мэргэжлийн шинжээчийг журмын 4.1-д заасны дагуу сонгоно.

4.4.Мэргэжлийн шинжээч нь энэхүү журмын хавсралтаар баталсан төслийн саналд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах хуудсанд заасан шалгуур үзүүлэлт тус бүрд 0-5 онооны үнэлгээ өгнө.

5 оноо - шалгуур үзүүлэлтийг 85-100% хангасан,

4 оноо - шалгуур үзүүлэлтийг 65-84% хангасан,

3 оноо - шалгуур үзүүлэлтийг 50-64% хангасан,

2 оноо - шалгуур үзүүлэлтийг 25-49% хангасан,

1 оноо - шалгуур үзүүлэлтийг 11-24% хангасан,

0 оноо – шалгуур үзүүлэлтийг 0-10% хангасан.

4.5.Шалгуур үзүүлэлт тус бүрийн оноог тухайн шалгуурын эзлэх жинд харьцуулан тооцно. Эцсийн үнэлгээ нь жинлэсэн нийлбэр онооны дүн байна.

4.6.Мэргэжлийн шинжээчийн өгсөн үнэлгээ 65 хувь болон түүнээс дээш бол тухайн төслийг мэргэжлийн шинжээч хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэсэнд тооцно.

4.7.Тухайн төсөлд дүгнэлт гаргасан мэргэжлийн шинжээчдийн олонх нь хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэсэн тохиолдолд уг төслийг дараагийн шатны сонгон шалгаруулалтад оруулна.

4.8.Мэргэжлийн шинжээч нь өөрийн үнэлгээ, дүгнэлтийн үнэн зөвийг хариуцаж, гарын үсгээр баталгаажуулна.

Тав. Бусад зүйл

5.1.Мэргэжлийн шинжээчийн нэг төслийн саналд үнэлгээ, дүгнэлт өгөх ажлын хөлсийг Засгийн газраас тогтоосон эрдэм шинжилгээний ажилтны нэг өдөрт ноогдох дундаж цалингийн 0.5-тай тэнцэх хэмжээгээр, нэг төслийн тайланд үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж, шүүмж өгөх ажлын хөлсийг эрдэм шинжилгээний ажилтны дундаж цалингийн нэг өдөрт ноогдох хэмжээгээр бодож Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас олгоно.

5.2.Төсөлд үнэлгээ, дүгнэлт гаргасан мэргэжлийн шинжээчийн нэр болон гаргасан үнэлгээ, дүгнэлтийг задруулахгүй.5.3.Мэргэжлийн шинжээч нь үнэлгээ, дүгнэлт гаргахаар танилцсан төсөлтэй холбоотой мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй ба төслийн талаарх мэдээллийг аливаа сонирхлоор ашиглах, задруулсан бол тухайн шинжээчийн шинжээчээр ажиллах эрхийг 3 хүртэл жилийн хугацаатай түдгэлзүүлж, мэдээллийн сангаас хасалт хийнэ.

Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын нэгдүгээр хавсралт

Үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин, %	Оноо /0-5/	Үнэлгээ, %
1	Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг улс, бүс, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх	15		
2	Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологид хамаарч буй эсэх	20		
3	Салбар дундын болон салбар дамнасан хамтын ажиллагаа, оролцоо	5		
4	Судалгааны ажлын онол, арга зүй нь төслийн зорилго, хүрэх үр дүнд нийцсэн эсэх	10		
5	Төсөл гүйцэтгэх багийн чадавх, туршлага (мэргэшсэн судлаачдын оролцоо)	10		
6	Лаборатори, туршилт-сорилтын бааз;	10		
7	Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө	5		
8	Төслийн өртөг зардлыг бодитой тооцсон эсэх;	5		
9	Үр дүнгийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаанд үзүүлэх үр нөлөө, ач холбогдол	20		
Нийт үнэлгээ		100%		
Санал /дэмжих эсэх/				

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../

Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын хоёрдугаар хавсралт

Суурь судалгааны төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин, %	Оноо /0-5/	Үнэлгээ, %
1	Төслийн сэдэв, зорилгыг оновчтой томъёолсон эсэх	10		
2	Сэдвийн судлагдсан байдал	10		
3	Шинжлэх ухааны шинэ таамаглал дэвшүүлсэн байдал болон шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн эсэх	20		
4	Судалгааны онол, арга зүй нь шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгааны зорилгод нийцсэн дэвшилтэт аргачлал ашигласан эсэх	20		
5	Төсөл гүйцэтгэх багийн чадавх, туршлага, салбарын, мэргэжлийн судлаачид хамтран оролцсон байдал	10		
6	Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө	5		
7	Төслийн өртөг зардлыг бодитой тооцсон эсэх	5		
8	Судалгааны үр дүнгийн нийгэм, эдийн засгийн болон шинжлэх ухааны ач холбогдол, цаашдын судалгааны суурь болох боломж	10		
9	Төсөл хэрэгжүүлэх лаборатори, туршилт-сорилтын бааз, ашиглагдах эх сурвалжууд	10		
Нийт үнэлгээ		100%		
Санал /дэмжих эсэх/				

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../

Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын гуравдугаар хавсралт

Хэрэглээний судалгааны төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин, %	Оноо /0-5/	Үнэлгээ, %
1	Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологид хамаарч буй байдал	10		
2	Нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэлд үзүүлэх үр нөлөө, үр өгөөж	10		
3	Судалгааны шинэлэг байдал, технологийн шийдэл	20		
4	Төслийн үр дүнг оюуны өмчөөр хамгаалах, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломж	10		
5	Судалгааны онол, арга зүй нь шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой аргачлал ашигласан эсэх	15		
6	Гүйцэтгэх багийн чадавх, туршлага /мэргэшсэн судлаачдын оролцоо/	10		
7	Лаборатори, туршилт-сорилтын бааз;	10		
8	Үр дүнг зах зээлд нэвтрүүлэх боломж, бизнес төлөвлөгөө, хэрэгжих боломж, эрсдэлийн үнэлгээ	10		
9	Төслийн өртөг зардлыг бодитой тооцсон эсэх	5		
Нийт үнэлгээ		100%		
Санал /дэмжих эсэх/				

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../

Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын дөрөвдүгээр хавсралт

Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин, %	Оноо /0-5/	Үнэлгээ, %
1	Инновацын тэргүүлэх чиглэлд хамаарч буй байдал	10		
2	Лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, зүгшрүүлэхэд чиглэсэн байдал	15		
3	Оюуны өмчөөр хамгаалагдсан, технологи дамжуулах, лицензийн гэрээгээр дамжуулах боломж	10		
4	Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн арга зүй шинжлэх ухааны үндэслэлтэй, хэрэгжих боломжтой эсэх	10		
5	Технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох түшиц байгууллагатай хамтарсан байдал	10		
6	Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлын төлөвлөгөө	5		
7	Гүйцэтгэх багийн чадавх, туршлага	10		
8	Үйлдвэрлэл, туршилт-сорилтын бааз	10		
9	Зах зээлийн эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх боломж, үр ашиг	15		
10	Үйлдвэрлэлийн техник технологийн баримт бичгийн иж бүрдэл, бэлэн байдал	5		
Нийт үнэлгээ		100%		
Санал /дэмжих эсэх/				

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../

Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын тавдугаар хавсралт

Хамтарсан төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин, %	Оноо /0-5/	Үнэлгээ, %
1	НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх; бүс нутаг, үндэсний, орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй шинжлэх ухаан, технологи, нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байдал	15		
2	Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд хамаарч буй байдал	15		
3	Сэдвийн судлагдсан байдал, шинжлэх ухааны ач холбогдол, шинэлэг дэвшилтэт тал	10		
4	Төсөл гүйцэтгэх багийн чадавх, туршлага /Салбар, мэргэжлийн судлаачид хамтран оролцсон байдал/	5		
5	Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон байдал	5		
6	Үр дүнгийн нийгэм, эдийн засгийн болон шинжлэх ухааны ач холбогдол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх бодит боломж	15		
7	Хүний нөөцийг хөгжүүлэх, эрдэмтэн солилцоо, лаборатори туршилтын баазыг бэхжүүлэхэд оруулах хувь нэмэр	15		
8	Мэдээллийг нээлттэй хуваалцах, мэдээллийн бааз үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал	10		
9	Судалгаа хөгжүүлэлтээс Монголын талд үлдэх бүх төрлийн үр ашиг	10		
Нийт үнэлгээ		100%		
Санал /дэмжих эсэх/				

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../